

**ХАН-УУЛ ЦОГЦОЛБОР СУРГУУЛИЙН 2023-2024 ОНЫ ХИЧЭЭЛИЙН ЖИЛИЙН 4 ДҮГЭЭР АНГИЙН МОНГОЛ ХЭЛНИЙ ХИЧЭЭЛИЙН АНГИ ДЭВШИХ ШАЛГАЛТЫН ДЭЛГЭРЭНГҮЙ БЛЮПРИНТ**

АНГИ		4 ДҮГЭЭР АНГИ								Нийт даалгаврын тоо	Нийт даалгаврын оноо	Агуулгын эзлэх хувь
ШАЛГАЛТ ҮРГЭЛЖЛЭХ ХУГАЦАА		60 МИНУТ										
ДААЛГАВРЫН ХЭЛБЭР		СОНГОХ ДААЛГАВАР				ЗАДГАЙ ДААЛГАВАР						
Үнэлгээний нэгж	Суралцахуйн зорилт	Мэдлэг ойлголт	Чадвар	Хэрэглээ	Бүгд	Мэдлэг ойлголт	Чадвар	Хэрэглээ	Бүгд			
Уншсанаа ойлгох	4.1б. Уншсан эхийн болон үлгэр, өгүүллэгийн бүтцийн холбоо хамаарлаас гол санааг ойлгосноо харуулах 4.1и. Уншсан зохиолын баатрын гадаад дүр байдлыг ургуулан бодож төсөөлөх	2/2	2/2		4/4		1/2		1/2	5	6	33%
Зөв бичих зохион найруулж бичих	4.2ж. Бусдыг сайн сайхан зүйлд уриалж, бүтцийн дагуу уриалга бичих 4.4а. Харин, ийм учраас, цаашилбал, үүнээс гадна, яагаад гэвэл, үүнээс болж, ба, бөгөөд зэрэг холбох үгсийг хэрэглэн, өгүүлбэр, эх зохиох	2/2	1/1		3/3		1/3	1/5	2/8	5	11	33%
Хэлгүй	4.2б. Балархай эгшгийн эгшигжүүлэх, зөөлрүүлэх үүргийг мэдэх, зөв бичих 4.2г. Хатуу, зөөлний тэмдгийн тусгаарлах үүргийг мэдэх, зөв бичих 4.2в. ж, ч,ш-ийн дараа и бичдэгийн учрыг мэдэх, зөв бичих	1/1	2/2		3/3		2/4		2/4	5	7	33%
<b>НИЙТ ДААЛГАВРЫН ТОО, ОНОО</b>		<b>5/5</b>	<b>5/5</b>		<b>10/10</b>		<b>4/9</b>	<b>1/5</b>	<b>5/14</b>	<b>15</b>	<b>24</b>	
<b>ОНООНЫ ЭЗЛЭХ ХУВЬ</b>		<b>50%</b>	<b>50%</b>		<b>100%</b>		<b>64%</b>	<b>36%</b>	<b>100%</b>		<b>60%</b>	<b>100%</b>

**ҮНЭЛГЭЭНИЙ ЖИН**

Үнэлгэний зорилт	Даалгаврын тоо	Онооны эзлэх хувь
Мэдлэг, ойлголтыг үнэлэх даалгавар	5	33%
Мэдлэгээ хэрэглэх чадварыг үнэлэх даалгавар	10	66%

### ОНООНЫ ХЭВИЙН ТАРХАЛТ

Танин мэдэхүйн түвшин	Сонгох даалгаврын оноо	Задгай даалгаврын оноо	Нийт оноо	Нийт онооны эзлэх хувь
Мэдлэг, ойлголт	5		5	28%
Чадвар	3	5	8	44%
Хэрэглээ		5	5	28%
<b>Нийт</b>	<b>8</b>	<b>10</b>	<b>18</b>	<b>100%</b>

### ҮНЭЛГЭЭНИЙ ДААЛГАВРЫН ХАРИУ, ҮНЭЛЭХ СХЕМ

№	Суралцахуйн зорилт	Танин мэдэхүйн түвшин	Зөв хариулт А	Зөв хариулт Б	Оноо	Онооны тайлбар
<b>СОНГОХ ДААЛГАВАР</b>						
1	4.1б. Уншсан эхийн болон үлгэр, өгүүллэгийн бүтцийн холбоо хамаарлаас гол санааг ойлгосноо харуулах	Мэдлэг ойлголт	Б	А	1	Зөв хариултын сонгосон бол 1 оноо
2	4.1и. Уншсан зохиолын баатрын гадаад дүр байдлыг ургуулан бодож төсөөлөх	Мэдлэг ойлголт	В	Б	1	Зөв хариултын сонгосон бол 1 оноо
3	4.2ж. Бусдыг сайн сайхан зүйлд уриалж, бүтцийн дагуу уриалга бичих	Мэдлэг ойлголт	Г	Б	1	Зөв хариултын сонгосон бол 1 оноо
4	4.4а. Харин, ийм учраас, цаашилбал, үүнээс гадна, яагаад гэвэл, үүнээс болж, ба, бөгөөд зэрэг холбох үгсийг хэрэглэн, өгүүлбэр, эх зохиох	Мэдлэг ойлголт	Г	А	1	Зөв хариултын сонгосон бол 1 оноо
5	4.1и. Уншсан зохиолын баатрын гадаад дүр байдлыг ургуулан бодож төсөөлөх	Мэдлэг ойлголт	А	В	1	Зөв хариултын сонгосон бол 1 оноо
6	4.1б. Уншсан эхийн болон үлгэр, өгүүллэгийн бүтцийн холбоо хамаарлаас гол санааг ойлгосноо харуулах	Чадвар	Б	Б	1	Зөв хариултын сонгосон бол 1 оноо
7	4.1и. Уншсан зохиолын баатрын гадаад дүр байдлыг ургуулан бодож төсөөлөх	Чадвар	Г	В	1	Зөв хариултын сонгосон бол 1 оноо

8	4.4а. Харин, ийм учраас, цаашилбал, үүнээс гадна, яагаад гэвэл, үүнээс болж, ба, бөгөөд зэрэг холбох үгсийг хэрэглэн, өгүүлбэр, эх зохиох	Чадвар	Г	А	1	Зөв хариултын сонгосон бол 1 оноо
9	4.2г. Хатуу, зөөлний тэмдгийн тусгаарлах үүргийг мэдэх, зөв бичих	Чадвар	Б	А	1	Зөв хариултын сонгосон бол 1 оноо
10	4.2в. ж, ч,ш-ийн дараа и бичдэгийн учрыг мэдэх, зөв бичих	Чадвар	Б	Б	1	Зөв хариултын сонгосон бол 1 оноо
<b>ЗАДГАЙ ДААЛГАВАР</b>						
11	4.1и. Уншсан зохиолын баатрын гадаад дүр байдлыг ургуулан бодож төсөөлөх	Чадвар	Навчийг модонд уясан Найзыгаа хурдан эрүүл болгохын тулд	Эрүүл болохыг өөрийгөө дайчилсан Хурдан эдгэрэхийн тулд	2	Эхэд тулгуурлан бичсэн бол 1 оноо, 2-3 өгүүлбэрээр боломжийн бичсэн бол 1 оноо
12	4.4а. Харин, ийм учраас, цаашилбал, үүнээс гадна, яагаад гэвэл, үүнээс болж, ба, бөгөөд зэрэг холбох үгсийг хэрэглэн, өгүүлбэр, эх зохиох	Чадвар	Ба, бөгөөд-үгийг үгтэй Харин-Өгүүлбэрийг өгүүлбэртэй	Ба, бөгөөд-үгийг үгтэй Үүнээс болж-Өгүүлбэрийг өгүүлбэртэй	3	Зөв холболт бүр 1 оноо, нийт 3 оноо
13	4.2в. ж, ч,ш-ийн дараа и бичдэгийн учрыг мэдэх, зөв бичих	Чадвар	Ирэхийг – сурахыг, бодохыг г.м	Нээлтэд-Сургалтад, уулзалтад г.м	2	Үг тус бүр 1 оноо, нийт 2 оноо
14	4.2г. Хатуу, зөөлний тэмдгийн тусгаарлах үүргийг мэдэх, зөв бичих	Чадвар	Эгшгээр төгссөн үгэнд я, ё, е-г шууд залган бичнэ.	Зөөлөрсөн гийгүүлэгчээр төгссөн үгэнэд я,ё,е-г шууд залган бичнэ.	2	Төгсгөлийг бичсэн бол 0.5 оноо, я,е,ё-г бичсэн бол 0.5 оноо, шууд гэж бичсэн бол 1 оноо
15	4.2ж. Бусдыг сайн сайхан зүйлд уриалж, бүтцийн дагуу уриалга бичих	Хэрэглээ	Уриалгыг төлөвлөгөөний дагуу, үгийн тоонд хүргэн, алдаагүй зөв бичсэн байна.		5	Өгсөн төлөвлөгөө тус бүр 1 оноо /3 чиглэл/, үгийн тоо 1 оноо, зөв бичгийн дүрэм 0.1 оноо

**ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН ХАН-УУЛ ЦОГЦОЛБОР СУРГУУЛИЙН 4 ДҮГЭЭР АНГИЙН МОНГОЛ  
ХЭЛ ХИЧЭЭЛИЙН АНГИ ДЭВШИХ ШАЛГАЛТЫН СЭДЭВ**

**А ХУВИЛБАР**

**НИЙТ ОНОО 24**

**ХУГАЦАА 40 МИНУТ**

**НЭГ. СОНГОХ ДААЛГАВАР**

**САНАМЖ:** Эхийг анхааралтай уншиж ойлгосны дараа даалгаврыг гүйцэтгээрэй. Сонгох даалгавар бүр 1 оноотой.

**СҮҮЛЧИЙН НАВЧ**

Өрөөнд дөрвөн охин байлаа. Зургаан настай Байгалмаа, Сүнжидмаа, Гүнжидмаа, хамгийн том Болормаа 12 настай аж. Арай эгчийн хувьд Болормаа тэдэндээ хуурай эгч нь болжээ.

Орноосоо босож чаддаггүй Байгалмаагаа нөгөө гурав нь юм л бол бөөцийлөх дуртай. Гэрээс ирсэн чихэр жимснийхээ аль сайхныг өгнө. Гэтэл Байгалмаа эдэн шиг хөл дээрээ хурдан босож, өрөөн дотуур дураараа алхахын жаргал ямар сайхан болохыг хэдий нялх балчир ч ухаарах сэтгэлээр шаналдаг байлаа.

Охины цонхон тушаа улиасны үзүүрийн хэдэн сэрвэгэр мөчир цухуйж харагдана. Гэтэл нэг өдөр Болормаа эгч нь гэнэт:

-Байгалмаа, миний дүү хараач. Энэ харагдаж буй навчнууд бүгд шарлан унасаар байгаад хамгийн сүүлчийн ганцхан навч үлдэнэ. Тэр навчийг унахаас өмнө л чи явж чаддаг болно. За юу! Чи харин хөлийнхөө дасгалыг сайн хийж байгаарай гэв.

Тэр өдрөөс хойш охины ажигладаг юм нь тэр болов. Нөгөө навчнууд ч шарлаж эхэллээ. Удахгүй ганц үлдэнэ. Тэр навчийг унахаас өрсөж л би явж чаддаг болох ёстой гэж сэмхэн янз янзаар туршдаг болов. Хийсээр л байлаа. Сүүлдээ үнэхээр ганц навч үлдэв. Зүрх шиг тэр бяцхан ганц навч түүний найдвар болов. Найдвар төдийгүй өнөөх навчаа уначихвий гэж айх болов.

Нэг өдөр Байгалмаагийнхаа баярлан дуу алдах чимээнээр нөгөө гурав нь нойрноос сэрэн ухасхийв.

-Хүүе хараач! Би явж чаддаг болсон. Бүр огт өвдөхгүй байна, хараач! гэж охин баярлан өгүүлэв. Ядарсандаа духны хөлс нь чийхарсан байлаа.

Энэ баяр хөөр тэр дөрвийн баяр байлаа. Харин орой нь Байгалмаагаа бөх гэгч нойрсож байх үеэр Болормаа сэмхэн гараад, нөгөө навчийг мөчирт нь бөхөлж уясан утсыг эвтэйхэн тайлан авчээ.

З.Далхжав

1. Байгалмаа охин хэдэн настай вэ?  
А. 12 настай      Б. 6 настай      В. Хуурай эгч      Г. Сургуульд орсон.
2. Болормаа хэрхэн нэрлэдэг вэ?  
А. Эгч      Б. Охид      В. Хуурай эгч      Г. Сайн эгч
3. Орноосоо босож чаддаггүй Байгалмаагаа нөгөө гурав нь юм л бол ..... дуртай.  
А. Хайрлах      Б. Өгөх      В. Дургүй      Г. Бөөцийлөх
4. Болормаа охин сэмхэн гараад юуг тайлан авсан бэ?  
А. Мөчрийг      Б. Навчийг      В. Цэцгийг      Г. Уяаг
5. Байгалмаа охин юуны учир баярласан бэ?  
А. Алхаж чадсан      Б. Бие нь сайжирсан      В. Баярласан      Г. Өдчтэй учир
6. Болормаа яагаад хуурай эгч нь болсон бэ?  
Б. Бүгд түүнийг эгч гэдэг учир      В. Арай эгчийн хувьд  
В. Нэг л мэдэхэд хуурай эгч болсон      Г. Эгч биш
7. Холбох үгийг сонгоорой.  
А. минь      Б. мөн      В. нь      Г. Ба
8. Зөв харгалзуулаарай  
1. Тариа ногоогоо      а. тарья  
2. Одоо бүгдээрээ      б. тарья  
А. 1б, 2а      Б. 1б, 2б      В. 1а, 2а      Г. 1а, 2б

9. Алдаатай бичсэн үгийг олоорой.

- А. Амжилт                      Б. Цочох                      В. ажил                      Г. Заншил

10. Бусдад хандаж, тэднийг сайн сайхан зүйлд уриалж дуудаж бичсэн нь ..... юм.

- А. Захидал                      Б. Уриалга                      В. Талархал                      Г. Бичих

### ХОЁР. ЗАДГАЙ ДААЛГАВАР

Санамж: Даалгаврыг орхигдсон зайнд нөхөж бичээрэй.

11. Болормаагийн хийсэн үйлдэл, шалтгааныг бичээрэй. /2/

Болормаагийн хийсэн үйлдэл	Шалтгаан нь

12. Зөв холбоорой. /3/

Үүнээс болж

бөгөөд

ба

А. Үгийг үгтэй холбох нь

Б. Өгүүлбэрийг өгүүлбэртэй холбох нь

13. Үгийн дүрмийг ажиглан ижил бичлэгтэй үг 2-ыг бичээрэй. /2/

Ирэхийг - .....

14. нээ+е=нээе. Дүрмийг тайлбарлан бичээрэй. /2/

.....

15. Ангийнхандаа хандаж “Зуны амралтаараа эцэг эхдээ тусалцгаая” уриалга бичээрэй. Үгийн тоо 40 – 60 /5 оноо/

Эхлэл хэсэгт: Хэнд хандаж, юуг уриалах гэж байгаагаа бичих

Гол хэсэгт: Уриалга бичих болсон шалтгаанаа бичих

Төгсгөл хэсэгт: Уриалахыг хүссэн чухал зүйлээ товч бичих, хэн уриалсныг бичнэ үү.

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

**ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН ХАН-УУЛ ЦОГЦОЛБОР СУРГУУЛИЙН 4 ДҮГЭЭР АНГИЙН МОНГОЛ  
ХЭЛ ХИЧЭЭЛИЙН АНГИ ДЭВШИХ ШАЛГАЛТЫН СЭДЭВ**

**Б ХУВИЛБАР**

**НИЙТ ОНОО 24**

**ХУГАЦАА 60 МИНУТ**

**НЭГ. СОНГОХ ДААЛГАВАР**

**САНАМЖ:** Эхийг анхааралтай уншиж ойлгосны дараа даалгаврыг гүйцэтгээрэй. Сонгох даалгавар бүр 1 оноотой.

**СҮҮЛЧИЙН НАВЧ**

Өрөөнд дөрвөн охин байлаа. Зургаан настай Байгалмаа, Сүнжидмаа, Гүнжидмаа, хамгийн том Болормаа 12 настай аж. Арай эгчийн хувьд Болормаа тэдэндээ хуурай эгч нь болжээ.

Орноосоо босож чаддаггүй Байгалмаагаа нөгөө гурав нь юм л бол бөөцийлөх дуртай. Гэрээс ирсэн чихэр жимснийхээ аль сайхныг өгнө. Гэтэл Байгалмаа эдэн шиг хөл дээрээ хурдан босож, өрөөн дотуур дураараа алхахын жаргал ямар сайхан болохыг хэдий нялх балчир ч ухаарах сэтгэлээр шаналдаг байлаа.

Охины цонхон тушаа улиасны үзүүрийн хэдэн сэрвэгэр мөчир цухуйж харагдана. Гэтэл нэг өдөр Болормаа эгч нь гэнэт:

-Байгалмаа, миний дүү хараач. Энэ харагдаж буй навчнууд бүгд шарлан унасаар байгаад хамгийн сүүлчийн ганцхан навч үлдэнэ. Тэр навчийг унахаас өмнө л чи явж чаддаг болно. За юу! Чи харин хөлийнхөө дасгалыг сайн хийж байгаарай гэв.

Тэр өдрөөс хойш охины ажигладаг юм нь тэр болов. Нөгөө навчнууд ч шарлаж эхэллээ. Удахгүй ганц үлдэнэ. Тэр навчийг унахаас өрсөж л би явж чаддаг болох ёстой гэж сэмхэн янз янзаар туршдаг болов. Хийсээр л байлаа. Сүүлдээ үнэхээр ганц навч үлдэв. Зүрх шиг тэр бяцхан ганц навч түүний найдвар болов. Найдвар төдийгүй өнөөх навчаа уначихвий гэж айх болов.

Нэг өдөр Байгалмаагийнхаа баярлан дуу алдах чимээнээр нөгөө гурав нь нойрноос сэрэн ухасхийв.

-Хүүе хараач! Би явж чаддаг болсон. Бүр огт өвдөхгүй байна, хараач! гэж охин баярлан өгүүлэв. Ядарсандаа духны хөлс нь чийхарсан байлаа.

Энэ баяр хөөр тэр дөрвийн баяр байлаа. Харин орой нь Байгалмаагаа бөх гэгч нойрсож байх үеэр Болормаа сэмхэн гараад, нөгөө навчийг мөчирт нь бөхөлж уясан утсыг эвтэйхэн тайлан авчээ.

З.Далхжав

1. Болормаа охин хэдэн настай вэ?  
А. 12 настай      Б. 6 настай      В. Хуурай эгч      Г. Сургуульд орсон.
2. Хуурай эгч хэн нь вэ?  
А. Байгалмаа      Б. Болормаа      В. Сүнжидмаа      Г. Гүнжидмаа
3. Гэрээс ирсэн чихэр жимснийхээ аль ..... өгнө.  
А. Ихийг      Б. Сайхныг      В. Бүгдийг      Г. Өгдөггүй
4. Цонхон тушаа юу харагддаг вэ?  
А. Мөчир      Б. Сэрэвгэр      В. Цонх      Г. Юу ч харагддаггүй
5. Байгалмаа охины ямар чимээнээр найз охид сэрсэн бэ?  
А. Уйлах      Б. Хашхирах      В. Баярлах      Г. Мэдэхгүй
6. Болормаа яагаад хуурай эгч нь болсон бэ?  
Б. Бүгд түүнийг эгч гэдэг учир      Б. Арай эгчийн хувьд  
В. Нэг л мэдэхэд хуурай эгч болсон      Г. Эгч биш
7. Холбох үгийг сонгоорой:  
А. Үгүй      Б. нь      В. Бөгөөд      Г. Маань
8. Зөв харгалзуулаарай  
1. Найзыгаа гэртээ      а. урья  
2. Хэрэггүй цаасаа      б. урья  
А. 1б, 2а      Б. 1б, 2б      В. 1а, 2а      Г. 1а, 2б

9. Алдаатай бичсэн үгийг олоорой.

А. Амжалт                  Б. Цочих                  В. ажил                  Г. заншил

10. Бусдад хандаж, тэднийг ..... зүйлд уриалж дуудаж бичсэн нь уриалга юм.

А. Алс холоос                  Б. Сайн сайхан                  В. Муу муухай                  Г. талархан

### **ХОЁР. ЗАДГАЙ ДААЛГАВАР**

**Санамж:** Даалгаврыг орхигдсон зайнд нөхөж бичээрэй.

11. Байгалмаагийн хийсэн үйлдэл, шалтгааныг бичээрэй. /2/

Байгалмаагийн баярлахдаа хийсэн үйлдэл	Шалтгаан нь

12. Зөв холбоорой. /3/

ба    А. Үгийг үгтэй холбох  
бөгөөд                                      Б. Өгүүлбэрийг өгүүлбэртэй холбох  
Харин

13. Үгийн дүрмийг ажиглан ижил бичлэгтэй үг 2-ыг бичээрэй. /2/

Нээлтэд - .....

14. харь+я=харья. Дүрмийг тайлбарлан бичээрэй. /2/

15. Ангийнхандаа хандаж “Зуны амралтаараа ажил хөдөлмөрт суралцацгаая” уриалга бичээрэй.

Үгийн тоо 40 – 60 /5 оноо/

Эхлэл хэсэгт: Хэнд хандаж, юуг уриалах гэж байгаагаа бичих

Гол хэсэгт: Уриалга бичих болсон шалтгаанаа бичих

Төгсгөл хэсэгт: Уриалахыг хүссэн чухал зүйлээ товч бичих, хэн уриалсныг бичнэ үү.

.....  
.....  
.....  
.....  
.....  
.....  
.....  
.....  
.....  
.....  
.....  
.....  
.....  
.....  
.....  
.....  
.....  
.....  
.....  
.....  
.....  
.....  
.....